

Эдийн засгийн өсөлт 11% (II улирал)


ДНБ энэ оны эхний хагас жилийн байдлаар 6.2 их наяд төгрөгт (4.6 тэрбум ам.доллар) хүрч, өнгөрсөн оны мөн үеэс 25%, харин 2005 оны зэрэгцүүлэх үнээр 2.4 их наяд төгрөг (1.8 тэрбум ам.доллар) болж, өнгөрсөн оны мөн үеэс 13% тус тус өссөн байна.

ДНБ-ий улирлын бодит өсөлт 11% хүрсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 3.8 нэгжээр бага байна.



Төсвийн алдагдал 0.6 их наяд төгрөг байна


Улсын нэгдсэн төсвийн орлого өнгөрсөн жилийн мөн үетэй харьцуулахад 21% өссөн бол зарлага түүнээс даруй 2.5 дахин хурдтай буюу 53% өссөн нь төсвийн тэнцвэржүүлсэн нийт тэнцэл 600 тэрбум төгрөгийн (0.4 тэрбум ам.доллар) алдагдалтай гарахад хүргэлээ. Орлого нэмэгдэхэд НӨАТ 27%, НДШ 58%, ХАОАТ 56%, ААНОАТ 10% тус тус өссөн нь нөлөөлжээ. Харин зарлага өсөхөд татаас ба шилжүүлэг 51%, хөрөнгийн зардал 101%, цалингийн зардал 50% өссөн нь нөлөөлөв.



Гадаад худалдааны алдагдал 1.4 тэрбум ам.доллар

Нийт бараа эргэлт энэ оны эхний 7 сарын байдлаар 6.5 тэрбум ам.долларт хүрсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 13% нэмэгдсэн байна. Экспорт 8%, импорт 15% тус тус өссөнөөс гадаад худалдааны алдагдал 1.4 тэрбум ам.доллар хүрлээ.

Экспортын өсөлтөд нүүрсний экспорт өмнөх оноос 30%, төмрийн хүдэр 30%, боловруулаагүй газрын тос 45% өссөн нь нөлөөлжээ. Харин зэсийн баяжмалын экспорт биет хэмжээгээрээ 0.4% нэмэгдсэн ч үнийн дүнгээрээ 16% буурсан байна. Импортын өсөлтөд дизель түлш 30%, автобензин 60%, суудлын автомашины импорт 21% өссөн нь голлон нөлөөлөв.



Төгрөгийн ам.доллартай харьцах ханш суларсаар байна


Төгрөгийн ам.доллартай харьцах сарын дундаж ханш өмнөх сараас 1.2%, өнгөрсөн оны мөн үеэс 7.8% тус тус суларлаа. Гадаад валютын нийт албан нөөц өнгөрсөн сараас 4.5% буурсан бол өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 4.4% нэмэгдэв. V сараас эхэлсэн төгрөгийн ханш сулрах хандлага үргэлжилсээр байна.



Хүнсний барааны дундаж үнэ өнгөрсөн жилээс 25% өссөн байна

Улсын хэмжээгээр тооцсон жилийн инфляцын түвшин өмнөх сараас 0.2 нэгжээр буурч 14.5% хүрээд байна. Энэ нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 4.4 нэгжээр өндөр байгаа юм.


Үнийн дундаж түвшин өмнөх оны мөн үетэй харьцуулахад 14.5% нэмэгдэхэд хүнсний барааны үнэ 25%, зочид буудал, зоогийн газрын үйлчилгээний үнэ 23% өссөн нь голлон нөлөөлжээ.



Эх сурвалж: ҮСХ, МБ


Гүйлгээнд байгаа мөнгө өмнөх сараас буурав

M2 мөнгө өмнөх оны мөн үеэс 17.5% нэмэгдсэн бол өнгөрсөн сартай харьцуулахад 1.4% буурч 6.9 их наяд төгрөг (5.1 тэрбум ам.доллар) хүрчээ. Гүйлгээнд байгаа бэлэн мөнгө өнгөрсөн оноос 19% өндөр байгаа бол өмнөх сараас 10% буурч, нийт мөнгөний 11.5%-ийг эзэлж байна. Мөнгөний нийлүүлэлт өмнөх сараас буурахад гүйлгээнд байгаа мөнгө, тэр дундаа банкнаас гадуурх мөнгөний хэмжээ буурсан нь нөлөөлжээ.




Валютын хадгаламж өсч байна

Хадгаламжийн хэмжээ өмнөх онтой харьцуулахад 25.9%, өнгөрсөн сартай харьцуулахад 1.1% нэмэгдэж, 4.4 их наяд төгрөгт (3.3 тэрбум ам.доллар) хүрлээ. Төгрөгийн хадгаламж өмнөх оны мөн үетэй харьцуулахад 19% өссөн бол валютын хадгаламж 49% өсчээ. Харин өмнөх сартай харьцуулахад төгрөгийн хадгаламж 1.7% нэмэгдэж, валютын хадгаламж 0.1% буурсан үзүүлэлттэй байв. Нийт хадгаламжийн 71%-ийг төгрөгийн хадгаламж бүрдүүлж байна.



Чанаргүй зээлийн хэмжээ буурч байна

Зээлийн өрийн үлдэгдэл өмнөх сараас 1.7%, өнгөрсөн оны мөн үеэс 37.3% нэмэгдэж, 6.4 их наяд төгрөг (4.8 тэрбум ам.доллар) боллоо. Чанаргүй зээлийн хэмжээ өмнөх сараас 0.7%, өнгөрсөн оноос 20% буурч, нийт зээлд эзлэх хувь 4.8% хүрэв. Зээлийн жилийн хүү (жигнэсэн дундаж) өмнөх жилтэй харьцуулахад төгрөгийнх 0.9 нэгжээр, валютынх 0.7 нэгжээр нэмэгдэж тус тус 18.3%, 12.9% байна.



Эх сурвалж: УСХ, МБ

Сарын онцлох үйл явдал

- > Засгийн газар АН, ИЗНН 75 хувь, “Шударга ёс” эвсэл 25 хувь гэсэн харьцаагаар байгуулагдлаа.
- > Засгийн газрын хуралдаанаар “Монгол Улсын 2013-2017 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөр”-ийг батлав.
- > Монгол банк “Банкны зөвшөөрлийн журам”-ыг шинэчлэн баталлаа.
- > УИХ-ын нэгдсэн чуулганаар Монгол Улсын 27 дахь Ерөнхий сайдаар Н.Алтанхуяг томилогдов.

Хураангуй

Төсөв, гадаад худалдааны алдагдал улам нэмэгдэж, инфляци өндөр байгаа энэ үед шинэ засгийн газар эмхлэн байгуулагдаж байна. Төсвийн алдагдал энэ сард өссөн дүнгээр 0.4 тэрбум ам.доллар хүрлээ. Манай улсын төсвийн зардал орлогоосоо даруй 2.5 дахин хурдтай өсөж байна. Гадаад худалдааны алдагдал 1.4 тэрбум ам.доллар байна. Монголбанкнаас төгрөгийн ханшийг тогтвортой байлгахын тулд дуудлага худалдаа зохион байгуулдаг. Энэ сард 3 удаагийн дуудлага худалдаанд оролцон ам доллар худалдсан байна. Тэд ийнхүү интервенц хийж байгаа ч төгрөгийн ханш суларсаар байна. Ханш суларч буй нь импортын барааны үнийг өсгөх аюултай. Түүнчлэн экспортын үнийн дүн буурна. Тиймээс ханшийг тогтворжуулах нь чухал.

Он гарсаар эрчимтэй өсч ирсэн инфляцийн түвшин VI сараас саарч эхэлсэн. Жилийн инфляцийн түвшин 14,5% хүрч, өргөн хэрэглээний барааны үнийн өсөлт бага, дунд орлоготой иргэдэд илүү дарамт учруулж байна. Монгол Улсын дотоодын эдийн засаг ийнхүү асуудалтай байхад АНУ болоод Евро бүсийн орнуудын эдийн засгийн хямралын нөлөөгөөр Хятадын эдийн засгийн өсөлт буурч байгаа нь экспортын өсөлтөд сөргөөр нөлөөлж болзошгүй байсан. Гэтэл манай улсын гадаад худалдаа оны эхнээс өссөн дүнгээр харвал өнгөрсөн онтой харьцуулахад нэмэгдсэн ч сарын дүнгээрээ өмнөх сараас буурсан үзүүлэлт ажиглагдаад эхэллээ. VII сарын экспортын хэмжээ өмнөх сартай харьцуулахад 48,6% буурч 285 сая ам.дол болжээ. Экспортын дүн буурахад Хятад улсуу экспорт болж буй голлох түүхий эдүүд болох нүүрсний экспорт биет хэмжээгээрээ 69%, үнийн дүнгээрээ 71%, зэсийн баяжмал биет хэмжээгээрээ 18%, үнийн дүнгээрээ 23%, төмрийн хүдэр биет хэмжээгээрээ 41%, үнийн дүнгээрээ 43% буурсан нь нөлөөлжээ. Биет хэмжээ болон үнийн дүнгээрх өөрчлөлт төдийлөн зөрүүгүй байгаа нь түүхий эдийн экспорт үнийн бууралтаас бус тоо хэмжээний бууралтаас болж буурсаныг харуулж байна. Хэдийгээр оны эхнээс өссөн дүнгээр экспорт буураагүй харагдаж байгаа ч сарын дүнгээрээ ийнхүү буурчээ. Хэрэв экспорт цаашид унавал дотоодын үйлдвэрлэл унаж, инфляци улам хөөрөгдөнө.